



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Үйлчилгээ үзүүлэх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/115 дугаар захирамж, Газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээд үзүүлэх төрийн үйлчилгээний "Үйлчилгээ үзүүлэх журам"-ыг нэгдүгээр, үйлчилгээний "Хяналтын хуудас"-ны загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэжсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Нэгдсэн төвд үзүүлэх үйлчилгээний журам, хяналтын хуудасны загвар батлах тухай" А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАЗРЫН ДАРГА



Ц.ТУЛГА

Газрын даргын 2023 оны дугаар
сарын 17-ны өдрийн 17/17 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Газраас хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх, үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх мэдээллээр хангахад оршино.

1.2. Энэ журмаар үйлчилгээний төрөл, хугацаа, үйлчилгээний ажилтан, холбогдох ажил хариуцсан албан хаагч нарын хоорондын ажлын уялдаа холбоо, үүрэг, хариуцлага, хяналттай холбоотой харилцааг зохицуулна.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 1.3.1. "Үйлчилгээний ажилтан" гэж Газрын даргын тушаалаар томилогдсон ажилтан, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Оператор;
- 1.3.2. "Хяналтын хуудас" гэж газрын даргын тушаалаар батлагдсан маягтыг;
- 1.3.3. "eVarilga" гэж хот байгуулалт, барилгын зөвшөөрлийн мэдээ, мэдээллийг агуулсан, үйлчилгээний хүсэлт, шийдвэрлэлтийн явц, санал, асуулгын бүртгэл хөтлөх геопортал болон гар утасны аппликэйшн бүхий цахим системийг;

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЧИМ

2.1. Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн үүрэг болон эрх зүйн баримт бичгийг үйлчилгээ үзүүлэхэд баримтална.

2.2. Газрын дотоод үйл ажиллагаанд хэрэглэгддэг ISO-9001-2016 стандартыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУГАЦАА

3.1. Газар нь хүн, хуулийн этгээдэд дараах 8 төрлийн 36 үйлчилгээг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн операторын үйлчилгээ, угтах үйлчилгээний цонхоор, цахимаар өдөр тутам үзүүлнэ. Үүнд:

3.1.1. Төлөвлөлтийн даалгавар батлах (Ажлын 10 хоног)

- 3.1.1.1. Барилгажсан хэсэгт архитектур төлөвлөлтийн даалгавар батлах;
- 3.1.1.2. Гэр хорооллын бүсэд архитектур төлөвлөлтийн даалгавар батлах;
- 3.1.1.3. Тусгай хамгаалалттай газарт архитектур төлөвлөлтийн даалгавар батлах;
- 3.1.1.4. Инженерийн дэд бүтэц төлөвлөх даалгавар батлах;
- 3.1.1.5. Авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар батлах;

3.1.1.6.Ашиглалтын шаардлага хангахгүй барилгад архитектур төлөвлөлтийн даалгавар авах хүсэлт хүлээн авах;

3.1.1.7.Эргэлтийн цэгийн солбицол өөрчлөх;

3.1.1.8.Гадна талбайн тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлах;

3.1.1.9.Хот төлөвлөлтийн баримт бичгийн зургийн даалгавар батлах.

3.1.2.Загвар зураг батлах (Ажлын 10 хоног)

3.1.2.1.Барилгажилтын төсөл батлах;

3.1.2.2.Барилга байгууламжийн архитектурын загвар зураг батлах;

3.1.2.3.Авто зам, замын байгууламжийн загвар зураг батлах;

3.1.2.4.Гадна тохижилтын ажлын загвар зураг батлах;

3.1.2.5.Техник эдийн засгийн үндэслэл, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах.

3.1.3.Барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох (Ажлын 10 хоног)

3.1.3.1.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох;

3.1.3.2.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа сунгуулах;

3.1.3.3.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах;

3.1.3.4.Инженерийн шугам сүлжээний ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох;

3.1.3.5.Цахилгааны ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох;

3.1.3.6.Барилга байгууламжийг буулгах ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох.

3.1.4.Инженерийн шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх (Ажлын 5-7-хоног)

3.1.4.1.Инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын зураг зөвшилцөх;

3.1.4.2.Мэдээлэл холбооны шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх;

3.1.4.3.Дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх;

3.1.4.4.Цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх;

3.1.4.5.Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зөвшилцөх;

3.1.4.6.Хийн хангамж, сэргээгдэх эрчим хүчний шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх.

3.1.5.Барилга, байгууламжийг мэдээллийн санд бүртгэх, хаяг дугаар олгох (Ажлын 3-5 хоног)

3.1.5.1.Шинээр ашиглалтад орж байгаа барилгад хаяг дугаар олгох;

3.1.5.2.Хуучин барилгад хаяг дугаар олгох;

3.1.5.3.Зуслан, амины болон гэр орон сууцны барилгад хаяг дугаар олгох;

3.1.5.4.Хуучин хаягтай барилгад дахин тодорхойлолт олгох;

3.1.5.5.Улсын комиссын акт баталгаажсан барилгад дахин тодорхойлолт олгох.

3.1.6.Зурган мэдээллээр үйлчлэх (Ажлын 1 хоног)

3.1.6.1.Инженерийн шугам сүлжээний зурган мэдээлэл өгөх;

3.1.6.2.Хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зурган мэдээлэл авах;

3.1.6.3.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зурган мэдээлэл авах.

3.1.7.Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх (тэг тэнхлэг, байр зүй) (Ажлын 5-7 хоног)

3.1.7.1.Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх;

3.1.7.2.Гүйцэтгэлийн байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгэх;

3.1.8.Архивын лавлагаа олгох үйлчилгээ (Ажлын 3-5 хоног)

ДӨРӨВ.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ҮҮРЭГ

4.1.Үйлчилгээний ажилтан нь:

4.1.1.Үйлчилгээний хүсэлтийг батлагдсан хяналтын хуудасны дагуу бүрдлийг шалган, хуудасны тоог тэмдэглэх, өргөдлийн маягттай үйлчилгээг үнэн зөв гүйцэд бөглүүлж, eBarilga цахим системд цахим хувийн хэрэг үүсгэн бүртгэнэ.

4.1.2.Хүсэлтийг цахим системд хувиарлагдсан албан хаагчийн нэр, албан ажлын утасны дугаар, шийдвэрлэх хугацаа зэргийг тодорхой бичиж “ИРГЭН ТАНД” буюу буцах хуудсыг иргэнд өгнө.

4.1.3.Бүртгэсэн хүсэлтийн цаасан материалыг ажлын 8 цагт багтаан холбогдох хэлтсийн мэргэжилтэнд хүлээлгэн өгч гарын үсэг зуруулна.

4.1.4.Шийдвэрлэгдсэн хүсэлтийг албан хаагчаас хүлээн авахдаа бүртгэл хөтлөн авч, хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдэд хариуг хүлээлгэн өгөхдөө бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

4.1.5.eBarilga цахим системийг хүн, хуулийн этгээдэд сурталчилж заавар зөвлөмж өгч, үйлчилгээний тоо, мэдээ, тайланг заасан хугацаанд гарган тайлагнана.

4.1.6.Албан хаагчаас хүсэлтийг буцаасан тохиолдолд буцсан материалыг хүн, хуулийн этгээдэд бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

4.1.7.Шийдвэрлэсэн хүсэлтийг хүн, хуулийн этгээд ирж аваагүй тохиолдолд дахин мэдэгдэж хүлээлгэн өгөх талаар арга хэмжээ авч, тэмдэглэл хөтөлнө.

4.1.8.Үйлчилгээ, бүрдүүлэх материал, шийдвэрлэлтийн явцын талаар хүн, хуулийн этгээдийг үнэн зөв, тодорхой мэдээллээр ханган, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.

4.2.Ажил хариуцсан албан хаагч нь:

4.2.1.eBarilga цахим системийг тогтмол шалгаж цаасан баримтыг хүлээн авч хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын тухай мэдээллийг программд оруулж, үйлчлүүлэгчид цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэн, үйлчлүүлэгч хариутай танилцах боломжийг бүрдүүлнэ.

4.2.2.Шаардлагатай мэдээллийг зөвхөн албаны электрон шуудангийн хаягаар хүлээн авна.

4.2.3.Хариуцсан албан хаагч хүсэлтийн явц, шийдвэрлэлтийн талаарх тайлбарыг заавал бичиж хувийн хэрэгт хавсаргасан байна.

ТАВ. ТӨЛБӨР ХУРААМЖ.

5.1.Төлбөртэй үйлчилгээ авахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авахдаа төлбөр төлсөн нотлох баримтын хамт авна.

5.2.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг хүн, хуулийн этгээдэд олгохдоо төлбөрийн баримтыг авна.

ЗУРГАА. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА


6.1.eVarilga цахим системээр үзүүлж буй үйлчилгээний явцын тэмдэглэл, шийдвэрлэлтэд холбогдох нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

6.2.Захиргаа, санхүүгийн хэлтэс нь газраас үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавьж ажиллана.

6.3.Энэхүү журам болон Үйлчилгээний стандартыг зөрчсөн ажилтанд Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Газрын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----

Газрын даргын 2023 оны дугаар
сарын-ны өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

**БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ БАРИХ ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/.....

Холбоо барих утасны дугаар:

Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр:



Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:

д/д	Бүрдүүлэх материал	Холбогдох байгууллага	Тайлбар	Хуудас	
1	Иргэний үнэмлэх	Хүсэлт гаргагч иргэн	Хуулбар		
2	Иргэний өргөдөл		Эх хувь		
3	Хуулийн этгээдийн албан бичиг	Хүсэлт гаргагч хуулийн этгээд	Эх хувь		
4	Улсын бүртгэлийн гэрчилгээ				
5	Газрын эрхийн гэрчилгээ	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /хүсэлт гаргагч/	Хуулбар		
6	Газрын кадастрын зураг				
7	Газрын гэрээ				
8	Газрын одоогийн байдлын фото зураг	Хүсэлт гаргагч иргэн	Сүүлийн 7 хоногийн байдлаар		
9	Газрын гэрээ дүгнэсэн акт	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв /хүсэлт гаргагч/	Эх хувь		
Хүсэлт хүлээн авсан					
Огноо. оны сарын..... өдөр					
Нийт хуудас:					
Үйлчилгээний ажилтны нэр:/ /					

Жич: Барилга байгууламж барих хүсэлтийг хуульд заасны дагуу итгэмжлэгчээр дамжуулан шийдвэрлүүлж болох бөгөөд итгэмжлэлээ баталгаажуулан ирүүлэх шаардлагатай. Барилга байгууламж барих хүсэлтэд загвар зураг хүлээн авахгүй

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/606 дугаар захирамжийн дагуу үйлчилгээ хүссэн иргэн, хуулийн этгээд иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, бусад баримт бичгийг эх хувиар нь авчирсан тохиолдолд хуулбарыг **нотариатаар** баталгаажуулах шаардлагагүй.

Газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 27 ны өдрийн 04 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ БАРИХ ХҮСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/:

Холбоо барих утасны дугаар:

Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр:

Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:

д/д	Бүрдүүлэх материал	Холбогдох байгууллага	Тайлбар	Хуудас	
1	Иргэний үнэмлэх	Хүсэлт гаргагч иргэн	Хуулбар		
2	Иргэний өргөдөл		Эх хувь		
3	Хуулийн этгээдийн албан бичиг	Хүсэлт гаргагч хуулийн этгээд	Эх хувь		
4	Улсын бүртгэлийн гэрчилгээ				
5	Газрын эрхийн гэрчилгээ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Хуулбар		
6	Газрын кадастрын зураг				
7	Газрын гэрээ				
8	Газрын одоогийн байдлын фото зураг	Хүсэлт гаргагч	Сүүлийн 7 хоногийн байдлаар		
9	Газрын гэрээ дүгнэсэн акт	ДЦГ, БЦГ-ын Хамгаалалтын захиргаа	Эх хувь		

Хүсэлт хүлээн авсан

Огноо. оны сарын..... өдөр.



Нийт хуудас:.....

Үйлчилгээний ажилтны нэр:/ /

Жич: Барилга байгууламж барих хүсэлтийг хуульд заасны дагуу итгэмжлэгчээр дамжуулан шийдвэрлүүлж болох бөгөөд итгэмжлэлээ баталгаажуулан ирүүлэх шаардлагатай.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/606 дугаар “Хүнд суртлыг халж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийн дагуу үйлчилгээ хүссэн иргэн, хуулийн этгээд иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, бусад баримт бичгийг эх хувиар нь авчирсан тохиолдолд хуулбарыг **нотариатаар** баталгаажуулах шаардлагагүй.

Газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 1727 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨХ ДААЛГАВАР ОЛГОХ,
БАТЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч/Итгэмжлэгч/

Холбоо барих утасны дугаар

Төлөвлөж буй авто зам, замын байгууламжийн зэрэглэл:

Төлөвлөж буй авто зам, замын байгууламжийн байршил /чиглэлийн нэр/:

Ажлын нэр	Бүрдүүлэх материал	Туйм
ДААЛГАВАР ОЛГОХ	Хуулийн этгээдийн албан бичиг /хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх хугацааг тусгах/	
	Хуулийн этгээдийн гэрчилгээ	
	Захирамж, шийдвэр /хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто зам барих тохиолдолд Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай зөвшилцсөн баримт ирүүлэх/	
	Төлөвлөж буй авто зам, замын байгууламжийн схем зураг /ts.tumen-od@uda.ub.gov.mn цахим хаяг болон CD-ээр ирүүлнэ/	
	Газрын одоогийн байдлын фото зураг /сүүлийн 14 хоногийн байдлаар/	
	Нийт хуудасны тоо	

Анхаарах зүйлс: Албан бичигт авто зам, замын байгууламжийг барих хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх төлөвлөгөө, ашиглагчийн нэрийг тусгах шаардлагатай. Авто зам, замын байгууламжийг шинэчлэх, өргөтгөх бол тухайн байгууламжид чанар аюулгүй байдлын дүгнэлт гаргуулж хавсралтаар ирүүлэх. Материалын бүрдэл, загвар зураг нь зөрчилтэй бол хүсэлтийг он сар өдөр, шалтгааныг тодорхой бичиж буцаах бөгөөд хуулбарыг хадгална.


Жич:

Буцсан шалтгаан:

Хүсэлт хүлээн авсан мэргэжилтэн/ /
/нэр/
..... оны..... сарын.....өдөр

Хянаж баталгаажуулах мэргэжилтэн/ /
/ нэр /
..... оны..... сарын.....өдөр

Газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 07 дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

**БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ БАРИХ ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ
ХЯНАЛТЫН ХУУДАС
/ХЭСЭГЧИЛСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС/**

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/
Холбоо барих утасны дугаар:
Төлөвлөж буй барилга, байгууламжийн зориулалт:
Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:

д/д	Бүрдүүлэх материал	Холбогдох байгууллага	Тайлбар	Хуудас
1	Иргэний үнэмлэх	Хүсэлт гаргагч иргэн	Хуулбар	
2	Иргэний өргөдөл		Эх хувь	
3	Хуулийн этгээдийн албан бичиг	Хүсэлт гаргагч хуулийн этгээд	Эх хувь	
4	Улсын бүртгэлийн гэрчилгээ		Хуулбар	
5	Газрын эрхийн гэрчилгээ			
6	Газрын кадастрын зураг /шинэчилсэн байдлаар/			
7	Газрын гэрээ	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /хүсэлт гаргагч/		
8	Фото зураг /газрын одоогийн байдал/	Хүсэлт гаргагч	Газрын байдлыг ерөнхийд нь харуулсан зураг	
9	Газрын гэрээ дүгнэсэн акт	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв /хүсэлт гаргагч/	Эх хувь	
10	Хөрш залгаа иргэдийн санал	www.uda.ub.gov.mn цахим хуудасны "Үйлчилгээ" цэсэд байршуулсан загварын дагуу авна.		
11	Хүсэлтийн хариу хүлээн авах цахим хаяг			

Хүсэлт хүлээн авсан

Огноо. оны сарын..... өдөр.

Нийт хуудас:.....

Үйлчилгээний ажилтны нэр:/

/

Жич: Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг болон Иргэний хуулийн 134 дүгээр зүйлийн 134.2 дахь хэсэгт заасан хөрш залгаа өмчлөгчийн эрх үүргийг харилцан хүндэтгэх үүрэгтэй тул Захиргааны ерөнхий хуулийн 26.1 дэх заалтад “Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.” гэж заасны дагуу хөрш залгаа эд хөрөнгө өмчлөгчдөөс саналыг авч хавсаргана.

Барилга байгууламж барих хүсэлтийг хуульд заасны дагуу итгэмжлэгчээр дамжуулан шийдвэрлүүлж болох бөгөөд итгэмжлэлээ баталгаажуулан ирүүлэх шаардлагатай.

Барилга, байгууламжийн загвар зургийг Архитектур төлөвлөлтийн даалгавар гарсны дараа батлуулна.

Гэр хорооллын дахин төлөвлөлт, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах төслийн хил хязгаарт орсон тохиолдолд төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцсөн албан бичгийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулсан зурагтай хавсралтаар ирүүлэх.


Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн байршилд зөвшилцсөнөөс бусад иргэн, аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгохгүй байх тухай” А/459 дүгээр захирамжийн дагуу гэр хорооллын дахин төлөвлөлт, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах төслийн хил хязгаарт орсон тохиолдолд төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцсөн албан бичгийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулсан зурагтай хавсралтаар ирүүлэх.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/606 дугаар захирамжийн дагуу үйлчилгээ хүссэн иргэн, хуулийн этгээд иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, бусад баримт бичгийг эх хувиар нь авчирсан тохиолдолд хуулбарыг **нотариатаар** баталгаажуулах шаардлагагүй.

Бүрдүүлэх материалын бүрдэл, үнэлгээ хийхэд зөрчил гарсан бол барилга, байгууламж барих хүсэлтийг он сар өдөр, шалтгааныг тодорхой бичиж буцаах бөгөөд хуулбарыг хадгална. Батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар өөрчлүүлэх хүсэлтийг журмын дагуу шийдвэрлэнэ.

-----oO-----

Газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 11/27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВРЫН СХЕМ ЗУРГИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙН СОЛБИЦОЛ ӨӨРЧЛҮҮЛЭХ ХҮСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС


	ЗӨВШӨӨРӨВ	НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР	Гарын үсэг:
	ЭС ЗӨВШӨӨРӨВ		

Хүсэлт гаргагчийн мэдээлэл					
1	Иргэний нэр		Хуулийн этгээд, ААНБ-ын нэр		
	Утасны дугаар:		Утасны дугаар:		
Барилга, байгууламжийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх мэдээлэл					
2	Дүүрэг, хороо		Барилга, байгууламж баригдсан эсэх	Тийм	Үгүй
3	Нэгж талбарын дугаар		Архитектур төлөвлөлтийн даалгаврын дугаар, огноо		
4	Солбицол өөрчлүүлэх шалтгаан		Батлагдсан загвар зургийн огноо		
Хавсралтаар бүрдүүлсэн материал					
6	Архитектур төлөвлөлтийн даалгавар, схем зураг /хуулбар/		Газрын эрхийн гэрчилгээ /хуулбар/		Байр зүйн баталгаажсан зураг /хуулбар/
7	Батлагдсан ерөнхий төлөвлөгөө /хуулбар/		Газрын кадастрын зураг /хуулбар/		Байр зүйн зургийн файл
Нийт хуудас:.....					
Хүсэлт хүлээн авсан: 2023 оны сарын..... өдөр.					
Үйлчилгээний ажилтны нэр:/ /					

<i>Барилга, байгууламжийн эргэлтийн цэгийн солбицол өөрчилсөн мэдээлэл</i>				
8	Барилга, байгууламжийн эргэлтийн цэгийг зөөсөн	<i>Тийм</i>	Барилга, байгууламжийн талбай өөрчилсөн	<i>Тийм</i>
		<i>Үгүй</i>		<i>Үгүй</i>
9	Солбицол өөрчилсөн шалтгаан			
Танилцсан: Хэлтсийн дарга:...../				/
Хүсэлтийг судалж танилцуулсан мэргэжилтэн:...../				/

Жич: Барилга байгууламжийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлтийг ажлын 3 хоногт шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

Газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 27 -ны өдрийн 24 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
ГАДНА ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЗАГВАР ЗУРАГ БАТЛАХ ХҮСЭЛТИЙН
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч:...../Итгэмжлэгч/:.....
 Холбоо барих утасны дугаар:.....
 Төлөвлөж буй гадна тохижилтын нэр
 Төлөвлөж буй гадна тохижилтын байршил:.....

д/д	Бүрдүүлэх материал	Бүрдэл
1	Батлагдсан тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар	
2	Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгаврын схем зураг	
3	Загвар зураг	
4	Ерөнхий төлөвлөгөөг тоон байдлаар хавсаргах 3D, цахим хаягаар ирүүлэх	
Загвар зургийн бүрдэл		
1	Нүүр хуудас /Батлагдах/	
2	Тайлбар бичиг	
3	Байршлын схем, орчны тойм	
4	Одоогийн байдлын фото зураг	
5	Одоогийн байдлын судалгаа	
6	Ерөнхий төлөвлөгөө /Батлагдах/	
7	Хөдөлгөөний схем	
8	Авто, явган зам, зогсоол	
9	Ногоон байгууламж	
10	Тоглоомын талбай, амрах талбай, спортын талбай	
11	Гэрэлтүүлгийн байгуулалт	
12	Харагдах байдал /Төлөвлөлтийн орчинд эвлүүлсэн зураглал/	
Хүсэлт хүлээн авсан		
Огноо. оны сарын..... өдөр.		
Нийт хуудас:.....		
Үйлчилгээний ажилтны нэр:/ /		

Анхаарах зүйл:

Зөрчилгүй, иж бүрэн бүрдэлтэй загвар зургийг бүртгэж авна. Бүрдүүлэх материалын бүрдэл, загвар зураг нь зөрчилтэй бол хүсэлтийг он сар өдөр, шалтгааныг тодорхой бичиж буцаах бөгөөд хуулбарыг хадгална.

Зураг төслийн тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагын цахим хуудаснаас шалгах /<http://www.barilga.gov.mn/>

Загвар зургийн батлагдах хуудасны стандартыг шалгах /<http://www.uda.ub.gov.mn/>


Буцсан шалтгаан: -----

Хянаж баталгаажуулах мэргэжилтэн/

/

..... оны..... сарын.....өдөр

Газрын даргын 2023 оны дугаар
сарын-ны өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САНААЧИЛГААР
АВТО ЗОГСООЛ ТӨЛӨВЛӨХ ХҮСЭЛТИЙН МАТЕРИАЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

Хүсэлт гаргагч:...../Итгэмжлэгч:.....
Холбоо барих утасны дугаар:.....
Төлөвлөж буй байршил:.....

№	Материал	Бүрдэл
1	Авто зогсоол төлөвлөж буй байршлын схем зураг	
2	Төлөвлөж буй авто зогсоолын боловсруулсан төсөл /төсөв, ажлын график төлөвлөгөө/	
3	Газар эзэмшил, шугам сүлжээний байгууллагуудын тодруулга	
4	Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн 60-аас доошгүй хувийн мөнгөн дүнтэй өөрийн дансны хуулга /Банкны хуулга/	
5	Нийт хуудасны тоо	

Хүсэлт хүлээн авсан

Олгосон:оны сарын..... өдөр.

Үйлчилгээний ажилтны нэр:

Нийслэлийн Төрийн сан банк дахь 100200051054 дугаар дансанд тушаана.

**/Гүйлгээний утга: Иргэн бол заавал регистрийн дугаар, цахим хаяг, аж ахуй
нэгж бол байгууллагын регистрийн дугаар бичих/**


Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны
"Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол
төлөвлөх, барьж байгуулах" 175 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2 дугаар зүйлд
заасан материалын бүрдлийн дагуу хүлээн авна.

Хүсэлт хүлээн авч хэвлэсэн мэргэжилтэн

нэр

..... оны сарын өдөр.

Газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 04 ны өдрийн 04 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

НИЙТИЙН ЭДЭЛБЭРИЙН ГАЗРЫГ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХӨРӨНГӨӨР
ТОХИЖУУЛАХ, АШИГЛАХ, ХАМГААЛАХ ХҮСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Хүсэлт гаргагч:...../Итгэмжлэгч:.....

Холбоо барих утасны дугаар:.....

Төлөвлөж буй байршил:.....

№	Материал	Бүрдэл
1	Тохижилт хийх үндэслэл, зориулалт, газрын байршил хэмжээ	
2	Хийгдэх тохижилтын ажлын төлөвлөгөө	
3	Санхүүгийн эх үүсвэрийн мэдээлэл;	
4	Одоогийн байдлын судалгаа	
5	Нийт хуудасны тоо	

Хүсэлт шийдвэрлэлт

Олгосон: оны сарын..... өдөр.



Үйлчилгээний ажилтны нэр:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны "Нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөн байгуулах" 166 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5.7 дугаар зүйлд заасан материалын бүрдлийн дагуу хүлээн авна.

Хүсэлт хүлээн авч хэвлэсэн мэргэжилтэн

..... оны сарын..... өдөр.

Газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 07 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗАГВАР ЗУРАГ ЗӨВШИЛЦӨХ, БАТЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч/Итгэмжлэгч/
Холбоо барих утас
Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр
Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил
Альбом А4 А3 Ерөнхий төлөвлөгөө, 3D зургийг тоон байдлаар /цахим хаягаар ирүүлэх/

Хүсэлт хүлээн авсан	
Огноо оны сарын..... өдөр.	
Нийт хуудас:.....	
Үйлчилгээний ажилтны нэр:	/ /

Зөвшилцсөн мэргэжилтэн / /

Буцсан шалтгаан: -----

Зөвшилцсөн мэргэжилтэн / /



Жич: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг мөрдөх.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалын хавсралт Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журмын 4.3, 7.1 дүгээр заалтыг тус тус мөрдөх.

Архитектур төлөвлөлтийн даалгаврын шаардлага хангаагүй зураг төсөл боловсруулсан бол “Хот байгуулалтын тухай хууль”-ийн 22 дугаар зүйл заалт удаа дараа зөрчиж зураг төсөл боловсруулсан аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

..... оны сарын.....өдөр

Газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 11/27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖИЙН ЗАГВАР ЗУРАГ
БАТЛАХ ХҮСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/:

Холбоо барих утасны дугаар:

Төлөвлөж буй гадна зар сурталчилгааны нэр, ангилал



.....

Төлөвлөж буй байршил:

д/д	Бүрдүүлэх материал	Бүрдэл
1	Гадна зар сурталчилгаа байрлуулах үндэслэл	
2	Гадна зар сурталчилгааны байгууламжийн загвар зураг	
3	Гадна зар сурталчилгаа байрлуулах газрын зураг, солбицлын цэг /CD-нд хуулбарлах/	
Загвар зургийн бүрдэл		
1	Нүүр хуудас /Батлагдах/	
2	Гадна зар сурталчилгаа байрлуулсан ерөнхий төлөвлөгөө /Батлагдах/	
3	Ерөнхий төлөвлөгөөний түлхүүр байгуулалтууд, зай хэмжээ	
4	Гадна зар сурталчилгааны байгууламжийн байгуулалт, хэсэглэл	
5	Гадна зар сурталчилгааны байгууламжийн зургийн эвлүүлэг, харагдах байдал	
Хүсэлт хүлээн авсан		
Огноо. оны сарын..... өдөр.		
Нийт хуудас:.....		
Үйлчилгээний ажилтны нэр:/		/

Жич: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам" 9/10 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4.1 дүгээр зүйлд заасан материалын бүрдлийн дагуу хүлээн авна.

Газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 1127 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
ЗАГВАР ЗУРАГ ЗӨВШИЛЦӨХ, БАТЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хүсэлт гаргагч/Итгэмжлэгч/

Холбоо барих утас

Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр

Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил

Альбом А4 А3 Ерөнхий төлөвлөгөө, 3D зургийг тоон байдлаар /цахим хаягаар ирүүлэх/

Хүсэлт хүлээн авсан

Огноо оны сарын..... өдөр.

Нийт хуудас:.....

Үйлчилгээний ажилтны нэр:/ /

Зөвшилцсөн мэргэжилтэн / /

Буцсан шалтгаан: -----

Зөвшилцсөн мэргэжилтэн..... / /



Жич: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг мөрдөх.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”-ын 4.3, 7.1 дүгээр заалтыг тус тус мөрдөх.

Архитектур төлөвлөлтийн даалгаврын шаардлага хангаагүй зураг төсөл боловсруулсан бол “Хот байгуулалтын тухай хууль”-ийн 22 дугаар зүйл заалт удаа дараа зөрчиж зураг төсөл боловсруулсан аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

..... оны сарын өдөр

Газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/.....
Холбоо барих утасны дугаар:
Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр:
Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:

Тайлбар:

1. Барилгын тухай хуулийн 20.2-т заасан барилга байгууламж барих барилгын ажлын зөвшөөрлийг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. ЛУИХ 2022.04.22. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/
2. Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-т заасан зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна гэж заасны дагуу холбогдох материалуудыг скайнердаж PDF өргөтгөлтэйгөөр цаасан болон цахим хэлбэрээр BAZG@uda.ub.gov.mn хаягаар ирүүлнэ үү. PDF өргөтгөлтэй файлын хэмжээ 5MB-ээс доош байна.
3. Материалын бүрдлийг PDF өргөтгөлтэй цахим хэлбэрээр ирүүлээгүй тохиолдолд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгогдохгүй болохыг анхаарна уу.

НЭГ. БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ			
№	Үндэслэл, хуулийн заалт	Баримт бичгийн жагсаалт, тайлбар	Бүрдэл
1.	Барилгын тухай хууль 28.2, 37.1 Барилгын ажлын захиалагч нь барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ.	Захиалагчийн өргөдөл, албан бичиг. Иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар Жич: Хүсэлтийг зөвхөн захиалагчаас ирүүлэх.	
2.	Барилгын тухай хууль 28.2.1. Барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр.	Газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, Архитектур төлөвлөлтийн даалгавар, Загвар зураг, Хангагч байгууллагуудаас олгосон техникийн нөхцөлүүд. Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.	

3.	Барилгын тухай хууль 28.2.2. Барилга байгууламжийн магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлт.	Батлагдсан загвар зургийн дагуу боловсруулж магадлал хийгдсэн ажлын зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, хавсралтын хамт.
4.	Барилгын тухай хууль 16.2, 16.4. Барилга байгууламжийн тэг тэнхлэгийг зураг төсөлд тэг тэнхлэгийг зураг төсөлд заасны дагуу геодезийн тэмдэглэгээ /улаан шугам/-тэй уялдуулан тухайн барилгын ажлын талбайд барилгын геодези, зураг зүйн ажил эрхлэх эрх бүхий хуулийн этгээд тогтоож мэдээллийг нутгийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	Хот байгуулалт, хөгжлийн газрын Хот байгуулалтын мэдээллийн хэлтсийн мэдээллийн санд оруулсан барилгын тэг тэнхлэгийг газарт шилжүүлсэн актын хуулбар
5.	Барилгын тухай хууль 28.2.3. Зураг төсөл зохиогч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Зураг төсөл зохиогч байгууллагын танилцуулга, Улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар <i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i>
6.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Барилгын тухай хууль 28.2.4. Байгаль орчны хууль тогтоомжийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн үнэлгээний тайлан.	Дараах зориулалтын барилга байгууламжид хамаарна: -1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц, -35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, -тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам, -орон нутгийн чанартай зам, холбоо, -шатахуун түгээх станц, -50 хүртэл болон 50-аас дээш ор хоногийн хүчин чадалтай зочид буудал, амралт, сувилал, бусад үйлчилгээний газар -аялал, жуулчлал эрхлэх, -10000-аас дээш хүн амтай төв, суурин газрын усан хангамж, цэвэрлэх байгууламж, хог хаягдлын нэгдсэн цэг. <i>Жич: Дээр дурдсанаас бусад зориулалтын барилга байгууламжид шаардахгүй.</i>
7.	Барилгын тухай хууль 8.2, 8.3, 8.4, 28.2.5. Барилгын үйл ажиллагаанд оролцогчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлыг даатгуулна. Барилгын ажлын гүйцэтгэгч тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна.	Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч нь тухайн барилга байгууламж дээр ажиллах ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулж гэрчилгээг хавсаргах. <i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i>

8.	Барилгын тухай хууль 28.3. Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгээс гадна зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргана.	Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар <i>Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.</i>	
9.	Барилгын тухай хууль 28.4, 30.1 Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсаргана. Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.	Барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх календарчилсан график төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлэх. <i>Жич: Барилгын ажлын зөвшөөрлийг календарчилсан график төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно.</i>	
10	Барилгын тухай хууль 16.3. Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна.	Барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэх барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг төслийг барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр баталгаажуулж ирүүлэх.	


Зөвлөмж:

1. Зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээд нь Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ гарсны дараа Тэмдэгтийн хураамж **20.000₮**-ийг Төрийн сан **100200051054** дугаар дансанд тушаана уу. **Жич: Гүйлгээний утга: Иргэн бол заавал регистрийн дугаар, цахим хаяг, аж ахуй нэгж бол байгууллагын регистрийн дугаар, цахим хаяг бичих.**
2. Барилгын тухай хуулийн 26.2: Барилга байгууламжийн үндсэн бүтээцэд болон инженерийн шугам сүлжээний хэмжээ, хүчин чадалд өөрчлөлт оруулсан бол зураг төслийг дахин боловсруулж, барилгын ажлын зөвшөөрөл шинээр авна гэж заасны дагуу дээрх материалыг дахин бүрдүүлж зөвшөөрлийг шинээр авна.
3. Барилгын тухай хуулийн 30.2: Барилгын ажил энэ хуулийн 30.1-д заасан хугацаанд дуусаагүй бол захиалагч зөвшөөрлийн хугацаа дуусахаас **30** хоногийн өмнө сунгуулах хүсэлтийг энэ хуулийн 27.1-д заасан байгууллагад гаргаж, дуусаагүй ажлыг гүйцэтгэх бодит хугацааг тусгасан төлөвлөгөөг хавсаргана гэж заасан тул ажил дуусах хугацааг сайтар бодолцож календарчилсан графикаа батлах нь зүйтэй.
4. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн 4.8: Барилгын тухай хуулийн 30.2-т заасан хугацаанд зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлт ирүүлээгүй бол Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгахгүй бөгөөд зөвшөөрлийн хугацаа дуусмагц гэрчилгээг хүчингүйд тооцно.

Хүсэлт хүлээн авсан мэргэжилтэн /...../

..... оны..... сарын.....өдөр

Газрын даргын 2023 оны 17 дугаар сарын 17-ны өдрийн 04 дугаар тушаалын хоёрдугаар хэсэрт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА
СУНГУУЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хүсэлт гаргагч:/Итгэмжлэгч/.....

Холбоо барих утасны дугаар:.....

Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр:.....

Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:.....

Тайлбар:

1. Барилгын тухай хуулийн 20.2-т заасан барилга байгууламж барих барилгын ажлын зөвшөөрлийг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. ЛУИХ 2022.04.22. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/
2. Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-т заасан зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна гэж заасны дагуу холбогдох материалуудыг скайнердаж PDF өргөтгөлтэйгөөр цаасан болон цахим хэлбэрээр BAZG@uda.ub.gov.mn хаягаар ирүүлнэ үү. PDF өргөтгөлтэй файлын хэмжээ 5MB-ээс доош байна.
3. Материалын бүрдлийг PDF өргөтгөлтэй цахим хэлбэрээр ирүүлээгүй тохиолдолд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгогдохгүй болохыг анхаарна уу.

ГУРАВ. БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ			
№	Үндэслэл, хуулийн заалт	Баримт бичгийн жагсаалт, тайлбар	БҮР
1.	Барилгын тухай хууль 28.2, 37.1 Барилгын ажлын захиалагч нь барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ.	Захиалагчаас барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа сунгуулах тухай дурдсан өргөдөл, албан бичиг ирүүлэх. Жич: Хүсэлтийг зөвхөн захиалагчаас ирүүлэх.	
2.	Барилгын тухай хууль 28.2.1. Барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр	Газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастр, Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.	
3.	Барилгын тухай хууль 37.1 Барилгын ажлын захиалагч нь барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ.	Урьд нь олгосон Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг хавсаргах. /МХЕГ, НМХГ, БХБЯ-аас олгосон зөвшөөрөл бол эх хувь байх/.	

4.	<p>Барилгын тухай хууль 28.4, 30.1</p> <p>Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсаргана.</p> <p>Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно. Хугацааг барилгын ажил эхлүүлэхээр заасан өдрөөс эхлэн тооцно.</p>	<p>Барилгын ажлын үе шатанд тавих хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх календарчилсан график төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлэх.</p> <p>Жич: <i>Барилгын ажлын зөвшөөрлийг календарчилсан график төлөвлөгөөнд заасан хугацаагаар олгоно.</i></p>	
